



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД
О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatnural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2024. 11. 04 № 26

Гэмт хэргийн хохирогчид нехэн төлбер
олгох сангийн хэрэгжилтийн талаар

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.4-т "Гэмт хэргийн хохирогчид нехэн төлбер олгох сан"-г тусгай сангийн төрөл гэж заасан байх бөгөөд Засгийн газрын 2020 оны "Журам шинэчлэн батлах тухай" 220 дугаар тогтоолын 2 дахь заалтад "Гэмт хэргийн хохирогчид нехэн төлбер олгох сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах"-ыг Хууль зүй, дотоод хэргийн сайдад даалгасан байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.1 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дахь хэсгийг тус тус үндэслэн, бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуултыг Танд тавьж байна. Үүнд:

- Гэмт хэргийн хохирогчид нехэн төлбер олгох сангийн төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт (гэмт хэргийн төрлөөр), нехэн төлber авсан хохирогчийн тоо болон бусад дэлгэрэнгүй мэдээллийг сүүлийн 10 жилийн байдлаар гаргаж, ирүүлнэ үү.

Энэхүү асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд ируулэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

О.НОМИНЧИМЭГ

